

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТӨЛӨӨХ ОРОЛЦОГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ

*Монголын уул уурхайн салбарт хамтын шийдвэр гаргах хүрээ зааг*

Монгол орны эрдэс түүхий эдийн баялаг нь үндэсний эдийн засгийн урт хугацааны өсөлт, хөгжил цэцэглэлд нэмэр хандив оруулж, ард иргэдийн аж байдал, үндэсний соёл, нийгмийн үнэт зүйлсийн тогтвортой хөгжлийг хангах чадавхи потенциалтай. Гэтэл энэхүү чадавхийг хяналтгүй уул уурхайн үйлдвэрлэл алдагдуулахад хүргэж болзошгүй.

Монгол улс эрүүл саруул хүн амын өсөлтийн зэрэгцээ байгалийн нөөц баялгаа өөрийн эдийн засгийг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд хэрхэн ашиглаж чадах вэ? Үүний нэг хариулт бол Хариуцлагатай уул уурхайг (ХУУ) хөгжүүлэх засаг төр, хувийн хэвшил болон төрийн бус сонирхлыг тусгаж чадсан Олон талын оролцогчдын үйл явц юм. Тус үйл явцад яам, гүйцэтгэх засаглалын байгууллагууд, УИХ-ын гишүүд, уул уурхай, түүнтэй холбогдох салбаруудын бизнес эрхлэгчид, түүнчлэн боловсролын байгууллагууд болон иргэдэд түшиглэсэн байгууллагууд оролцдог.

### Уул уурхай ба Монгол улсын эдийн засаг

Дэлхий нийтийн эдийн засаг эрчимтэй хөгжихийн хэрээр компьютерээс эхлээд хөнгөн тэрэг хүртэл олон төрлийн бэлэн бүтээгдэхүүн, бараа товар үйлдвэрлэхэд хэрэгцээтэй олон янзын материал түүхий эдийн хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна. Хятад улс хөрш зэргэлдээ оршиж, эрдэс түүхийн эдийн баялагтай (тухайлбал, нүүрс, алт, зэс г.м.) байгаа нь Монгол хөрөнгө оруулагчдыг татах чадвартай бөгөөд түүхий эд болон эцсийн бэлэн бүтээгдэхүүний чухал бэлтгэн нийлүүлэгч болж чадна гэсэн үг.

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн бараг 25 хувь буюу ойролцоогоор 40 сая га газрыг хамарсан 2,500 уул уурхайн тусгай зөвшөөрөл эдүгээ олгогдоод байна. Уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж байгаагийн дүнд 2005 онд тус салбар ДННБ-ний 17 хувийг үйлдвэрлэж, цаашид улам өсөх эдийн засгийн ашиг орлогыг буй болгов. Хэрэв Монгол улс эрдэс түүхий эдийн баялгаа ХУУ-г хөгжүүлэх замаар нээн илрүүлэн ашиглаж чадвал, ДННБ хурдацтай өсөх боломжтой.

### Иргэдийн хариу арга хэмжээ

Уул уурхайн үйлдвэрлэл 1990-ээд оноос өргөжин хөгжихийг дагаад тус салбарт хамааралтай нийгэм, байгаль орчны багц асуудал мөн гарч ирэх болсон. Соёл, нийгмийн болон газар ашиглалтын хэв маяг өөрчлөгдөх нь ард иргэдэд олон янзаар нөлөөлсөн. Зарим газар, газрын гадаргуу болон гүний усанд мөн зарим байдлаар нөлөөлж байгаа шинж тэмдгүүд илрэх болсон. Уул уурхайн салбарт хээл хахууль их газар авч байна гэсэнд сэтгэл түгших болсон нь Монголчууд шудрага наймаа, хэлэлцээр хийж чадахгүй байна гэсэн айдас төрүүлэх болов. Харин үүний улмаас алтны үнэ өсөх ба бусад шалтгаанаас болоод “нинжа” хэмээх жижиг алт олборлогчдын тоо хурдан өсөх болсон.

Нинжа нар мөнгөн ус болоод өөр химийн бодис хэрэглэж байгаа нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд ноцтой аюул занал учруулж байна.

Үүний улмаас иргэдийн анхан шатны байгууллагууд уул уурхайн компаниудад болон төр засагт ус, газрын баялгаа хамгаал гэсэн шаардлага шахалт үзүүлж эхэлсэн. Иргэдийн нөлөөллийн зэрэгцээ 2006 онд алт, зэсэнд ногдуулсан хэт их өндөр татвар нь Монголд уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын сонирхлыг буурахад хүргэв.

Эрдэс түүхий эд нь ирээдүйд үндэсний эдийн засгийн өсөлтийг санхүүжүүлэх орлогын нэг боломжит эх үүсвэр учраас хөрөнгө оруулагчдын итгэлийг ийнхүү алдах нь улс оронд ажлын байр тууштай буй болгох, хөгжин цэцэглэх ирээдүйд сөрөг нөлөө үзүүлэх аюултай. Гэвч урьдын адил, засаг төр ч, уул уурхайн компаниуд ч өөрийн үйл ажиллагааны талаар хариуцлага хүлээхгүй хэвээр. Байдал иймээс засаг, хувийн хэвшил болон иргэд эвсэн нийлж, Монголчуудын тусын тулд ХУУ-г хөгжүүлэхийн төлөө Олон талын оролцогчдын үйл явц буюу Чуулга уулзалтыг санаачилсан.



*Улаанбаатар зочид буудалд 2006 оны 11 сард чуулсан Монголд ХУУ-г хөгжүүлэхийн төлөөх анхны уулзалтад оролцохоор холбогдох талуудын 70 гаруй төлөөлөгчид цугларав.*

### Нийтлэг үндэслэлийг олж авах

2006 оны 9-р сараас эхлэн Монголын төрийн бус байгууллагууд, уул уурхайн компаниуд болон засаг төрийн хэд хэдэн тэргүүн төлөөлөгчид уул уурхайтай холбоотой асуудлаар ойр хамтран ажиллах, сөргөлдөөн багатай замаар яриа хэлэлцээ явуулахыг эрэлхийлж эхэлсэн.

АНУ-ын Азийн Сангаас зохион байуулсан сургалт-танилцуулах аяллыг зохиож, дээрх тэргүүн төлөөлөгчдийг Калифорни, Колорадо гэсэн газруудаар аялуулсан. Тэд өөрийн нүдээр уул уурхайн дэлхийн зэрэглэлийн менежмент, үйлдвэрлэлийн тэргүүн туршлагатай танилцахын зэрэгцээ, 1800-д онуудад Америк оронд хяналтгүй явагдсан уул уурхайн ажиллагааны хор уршиг, үр дагаврыг харж мэдсэн. Энэхүү сургалт нь харилцан ойлголцлын нийтлэг үндэслэл, харилцаа холбооны үндэс суурийг тавьж өгсөн. Сургалтын дүнд Монгол улсад нэвтрүүлүүштэй туршлагыг судлан, давтахаас зайлсхийвэл зохих сургамжийг тусгайлан танин мэдэж авсан.

2006 оны 11-р сард 30 гаруй байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн өргөн төлөөллийн дугуй ширээний уулзалтыг зохиож, Монгол улсын уул уурхайн салбар, түүнтэй холбоотой асуудлуудыг хэлэлцсэн. Дараагийн сард нь **ХУУ-н төлөө Олон талын оролцогчдын Чуулга уулзалт** гэдгийг үндэслэн байгуулсан. Тус Чуулга уулзалт нь “ХУУ-г хөгжүүлэх” харилцан ойлголцлын нийтлэг үндэслэлийг буй болгох хамтын үйл явц юм. Чуулганд оролцогчид холбогдогч бүх талыг тэгш байдлаар оролцуулсан нээлттэй, ил тод үйл явцын аргаар тодорхой үр дүнд хүрэхүйц яриа хэлэлцээ эхлүүлэхийг зорьсон.

#### **Хэлцэлд хүрсэн нь**

2006 оны 12-р сард болсон уулзалтаар холбогдогч талууд оролцоог зохицуулах багц суурь дүрэм журмын талаар тохирч, эхний ээлжинд явуулах үйл ажиллагааг тоймлон тодорхойлсон. 2007 оны 1-р сар гэхэд Ажлын хэсгээс ХУУ-н тодорхойлолт, суурь зарчмуудыг боловсруулан гаргасан. Эцсийн хувилбаруудад уг санаачлагын 51 гишүүн гарын үсэг зурсан. Үүний дараа хэсэг бүхэлдээ ХУУ-н Санаачлагын Тунхагийг баталж, улмаар 2007 оны 7-р сард гарын үсэг зурагчдын тоо 48 хүрсэн.

#### **Урагшлах хөдөлгөөн**

Практик амьдралд ХУУ чухам ямар байхыг харуулах стандартуудыг боловсруулахаар гишүүд Ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Тус Хэсгээс хуулийг мөрдөн сахиулахын тулд засгийн газраас гаргадаг зохицуулах стандартуудыг судалж, компаниудаас сайн дураар даган мөрдөх ажлын горимыг компаниуд баримталж байгаа эсэхийг шалгахад ашиглах стандартуудыг боловсруулж байна.

Үүнээс гадна, Ажлын хэсгээс ХУУ-н талаар судалгаа шинжилгээ, сургалтыг хөтөлбөр хэрэгжүүлэх, нөлөөллийн ажиллагаа явуулах тусгай байгууллага буюу төв байгуулах боломжийг судалж байна.

#### **“Ногоон алт” брендийг буй болгох**

Монголчууд төрийн албан хаагчид болон уул уурхайн компаниудаас хариуцлага тооцохыг улам ихээр шаардаж эхлэхийн хэрээр, зах зээл дээр “хариуцлагатай” компаниудын бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ буй болж эхэллээ. Хөдөлмөр, ой модны бүтээгдэхүүн, загасны бүтээгдэхүүн болон органик гаралтай бүтээгдэхүүнд зориулсан олон улсын гэрчилгээний тогтолцоо амжилттай хэрэгжиж байгаа нь компаниуд хариуцлагатай үйл ажиллагаа явуулахдаа ашигтай ажиллаж чадахыг харууллаа. Үнэн хэрэгтээ, олон хөрөнгө оруулагчид хамтран ажиллахаар ийм компаниудыг эрэлхийлж байна. Монгол улс энэхүү шинээр буй болж байгаа зах зээлд гарч ирэх боломжтой.

Кампуч улс саяхнаас хувцасны оёдлын үйлдвэрт хөдөлмөрийн үндэсний брэндийг буй болгосноор ийм замаар анхлан замналаа.

Тус орон дэлхийн зах зээлд өөрийн гэсэн танигдах нэрийн эрэлхийлж буй Nike, Gap гэсэн дэлхийд бараатай болж, шудрага хөдөлмөрийн баталгааг

*Олон талт үйл явц нь ХУУ-г хөгжүүлэх талаар ахиц гаргах сайхан боломжийг нээж өгч байна.*

*- Олон талт Чуулганд оролцогч*

алдартай компаниудыг өөртөө татах болсон.

Зах зээлийн худалдан авагчдаас ХУУ-н талаар тавигдах шаардлага хангахуйц “Ногоон алт” багц стандартыг боловсруулснаар Монгол улс өөрийгөө “ХУУ-н” олборлосон эрдэс түүхий эдтэй улс орон гэсэн нэрийг олж аван давуу талыг эдлэх болно. Санаачлагын оролцогчид энэ боломжийг олж авахын төлөө ажиллаж байна.

#### **Зохион байгуулагчийн үүрэг**

ХУУ-н Олон талын оролцогчдын Чуулга уулзалтыг анх АНУ-ын Азийн Сангаас засаг төр, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын сонирхол, хүсэлтийн дагуу зохион байгуулсан. Азийн Сан нь зохион байгуулагч, туслан дэмжигч, хурлын протокол хөтлөгчийн үүргийг гүйцэтгэж ирлээ. Чуулга уулзалтад оролцогчдын хүсэлтээр Сангаас тэдэнд ХУУ-г хөгжүүлэх хүч чармайлтад нь нэмэр болох үүднээс судалгаа явуулж хэрэгцээтэй баримт материалаар хангадаг. Энэхүү санаачлагыг хэрэгжүүлэхдээ Азийн Сан Нидерландын Хааны Элчин сайдын яамнаас санхүүжүүлж буй Ирээдүйгээ баталгаажуулах Хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авч ажиллаж ирсэн.

Тус нэгдсэн Хөтөлбөр нь Монгол улсад бүх холбогдогч талуудын сонирхлыг хамгаалан эдийн засгаа хөгжүүлж, ажлын байр буй болгоход нь туслахуйцаар харилцан яриа хэлцээ өрнүүлэх, сургалт явуулах, шаардлагатай бусад арга ажиллагаа явуулахыг эрчимжүүлэн твлхэц өгч байна.

#### **Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт**

Бүх оролцогч талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурлаж, хууль сахиу ёсыг дээдэлсэн, Монгол улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай гэнэ.

#### **Хариуцлагатай уул уурхайн зарчмууд**

- олон талын оролцоог хангах,
- ил тод нээлттэй байх,
- хуулийг сахин дээдлэх,
- байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх,
- ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах,
- үр өгөөжтэй байх,
- хүмүүнлэг ёс зүйтэй байх,
- дэвшилтэт технологид суурилсан байх.

#### **Оролцоо**

ХУУ-н төлөөх Олон талын оролцогчдын Чуулга уулзалт нь бүх оролцохыг хүсэгчдэд нээлттэй бөгөөд түүний гишүүд хэлэлцэх асуудлуудыг тогтоож, Чуулга уулзалтад тогтмол тайлагнах Ажлын хэсэгт сайн дураар орж ажилладаг. Цаашдын ажлын агуулга, чиглэлийн талаар гарах бүх шийдвэрийг оролцогчид хамтран тохирч гаргадаг.

Нэмэлт мэдээллийг URL

<http://www.asiafoundation.org/Locations/> веб хуудсанд орж, Эдийн засаг ба Байгаль орчин, Мэдээлэл ба Үйл явдал буюу Хэвлэн нийтлэгдсэн материалууд гэсэн нүүрүүднээс олж авах боломжтой. Эсхүл Монгол дахь Азийн Сан: Д. Хэрлэнтэй (976-11) 330-524 утсаар буюу [Kherlen@asiafound.mn](mailto:Kherlen@asiafound.mn). Цахим шуудангийн хаягаар холбоо барина уу.